

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
СТАНДАРТ, ХЭМЖИЛЗҮЙН ГАЗАР**

ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО

БАТЛАВ.

**БҮТЭЭГДЭХҮҮН, ТОГТОЛЦООНЫ
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА**

..... **В.ГАНЗОРИГ**
(Гарын үсэг)

2023 оны 08 сарын 03-ны өдөр

ХАЛАЛ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЖУРАМ

СХЗГ-07-ББ-14 (01):2023

Улаанбаатар хот

Баримт бичгийн нэр:		Халал баталгаажуулалтын журам	
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:		СХЗГ-07-ББ-14(01):2023	
Баталсан огноо:	2023.08.03	Баримт бичгийн хувилбар:	I

Баримт бичгийн түүх:

	Огноо	Овог нэр:	Албан тушаал:	Гарын үсэг:
Боловсруулсан:	2023.06.15	Лувсангончиг Золзаяа	БТБГ-ын ахлах Мэргэжилтэн	
Хэлэлцүүлсэн огноо:	Хэлэлцсэн хуралдаан: Ажлын хэсэг:	Хэлэлцүүлэгт оролцсон албан тушаалтан:	Албан тушаалтны гарын үсэг:	
2023 оны 08 дугаар сарын 01	Халал баталгаажуулал тын баг	Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газрын ахлах мэргэжилтнүүд		
Хүчин төгөлдөр мөрдөж эхлэх хугацаа:	2023.08.03			

..

Баримт бичгийн нэр:		Халал баталгаажуулалтын журам	
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:		СХЗГ-07-ББ-14(01):2023	
Баталсан огноо:	2023.08.03	Баримт бичгийн хувилбар:	I

**Баримт бичигт үзлэг хийсэн, нэмэлт өөрчлөлт, шинэчлэл
хийсэн тухай бүртгэл**

СХЗГ-ББ-01-Маягт05

Баримт бичгийн нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн хүснэгт

№	Бүлгийн дугаар	Хуудасны дугаар	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Шалтгаан	ЧМ-ийн гарын үсэг, огноо	БГ-ын даргын гарын үсэг, огноо
1	2	3	4	5	6	7
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						

Баримт бичгийн нэр:		Халал баталгаажуулалтын журам	
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:		СХЗГ-07-ББ-14(01):2023	
Баталсан огноо:	2023.08.03	Баримт бичгийн хувилбар:	I

АГУУЛГА

№	Гарчиг	Хуудасны дугаар
1	Ерөнхий зүйл	6х
2	Норматив эш таталт	6х
3	Нэр томьёо, тодорхойлолт	6-8х
4	Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалт	8х
5	Баталгаажуулалтад оролцогч байгууллагуудын эрх үүрэг	8х
6	Аудитын объект	9х
7	Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын баримт бичгүүд	9х
8	Баталгаажуулалтын үйл явц	9х
9	Баталгаажуулалтын өмнөх үйл ажиллагаа	9х
10	Баталгаажуулалтад хамрагдах хүсэлт гаргах	9х
11	Өргөдлийн дүн шинжилгээ	9х
12	Аудит явуулах	10-12х
13	Магадлах аудит	13х
14	Давтан баталгаажуулалт	13х
15	Хүрээ өргөтгөх	13х
16	Гэнэтийн аудит	13х
17	Баталгаажуулалтыг түдгэлзүүлэх, цуцлах, эсхүл хамрах хүрээг багасгах	14х
18	Өргөдөл, гомдол	14х
19	Баримтжуулалт, баримт бичгийн хадгалалт	14
20	Хавсралтууд (1-16)	15-33

Баримт бичгийн нэр:		Халал баталгаажуулалтын журам	
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:		СХЗГ-07-ББ-14(01):2023	
Баталсан огноо:	2023.08.03	Баримт бичгийн хувилбар:	I

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Энэхүү баримт бичиг нь GSO 2055-2; ISO/TS 22003; OIC/SMIIC 2; ISO/IEC 17065; ISO IEC 17021-1 стандарт болон бусад стандарт, баримт бичгээр тогтоосон шаардлагын дагуу Халал баталгаажуулалтыг хэрэгжүүлэхэд энэхүү журмыг баримтлана.

1.2 Энэхүү журмыг СХЗГ-ын Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газар болон Баян-өлгийн аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс (цаашид Баталгаажуулалтын байгуулага гэх) дагаж мөрдөнө.

1.3. Исламын шашин, дүрэмд нийцүүлэн халал бүтээгдэхүүний баталгаажуулалтыг хангах удирдлага, хяналтын нэгдсэн систем, халал шаардлагуудад нийцсэн баталгаажуулалтад мөрдөнө ажиллана.

2. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

Энэхүү журамд дараах хууль тогтоомж, стандарт, бусад баримт бичгийг эш татан хэрэглэсэн болно. Эш татсан баримт бичигт хугацаа заасан бол зөвхөн тухайн хэвлэлийг ашиглана. Хэрэв хугацаа заагаагүй бол эш татсан баримт бичиг болон түүнд өөрчлөлт оруулсан хамгийн сүүлчийн хэвлэлийг ашиглана. Үүнд:

2.1 “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол Улсын хууль.

2.2 GSO 2055-1 : General Requirements for Halal Food

2.3 GSO 993 Animal Slaughtering Requirements According to Islamic Rules.

2.4 GSO 2055-2 Conformity assessment – requirements for Bodies providing Halal Certification

2.5 OIC/SMIIC 1 General guidelines on Halal food

2.6 OIC/SMIIC 2:2019 “Тохирлын үнэлгээ. Халал баталгаажуулалт хийх байгууллагад тавих шаардлагууд”.

2.7 ISO 19011 “Менежментийн тогтолцооны аудитын заавар”.

2.8 ISO IEC 17000 Тохирлын үнэлгээ-Тайлбар толь, ерөнхий зарчим.

2.9 ISO/TS 22000 Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо.

2.10 ISO/IEC 17065 “Бүтээгдэхүүний баталгаажуулалтын байгууллагад тавих ерөнхий шаардлага”

2.11 ISO IEC 17021-1 Тохирлын үнэлгээ-Менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалтын гүйцэтгэх байгууллагад тавих шаардлага.

3. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү баримт бичигт хэрэглэхээр ISO/IEC 17021, ISO 22000, ISO IEC TS 22003, ISO 19011, ISO/IEC 17065, OIC/SMIIC 2; GSO 2055-2 стандартуудад заагдсан нэр томъёо, тодорхойлолтоос гадна дараах тодорхойлолтуудыг мөн хэрэглэнэ. Үүнд:

3.1 Аюулын шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт

Хүнсний аюулгүй байдалд ноцтойд тооцогдох аюулыг тогтоох, үнэлэх ба хянах тогтолцоо.

3.2 Хүнсний аюулгүй байдал

Зориулалтынх нь дагуу бэлтгэх болон хэрэглэх үед хүнс нь хэрэглэгчдэд хохирол учруулахгүй байх ойлголт.

3.3 Хүнсний аюултай байдал

Баримт бичгийн нэр:		Халал баталгаажуулалтын журам	
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:		СХЗГ-07-ББ-14(01):2023	
Баталсан огноо:	2023.08.03	Баримт бичгийн хувилбар:	I

Эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болох хүнсэн дэх химийн, физикийн, биологийн зүйл буюу хүнсний байдал.

3.4 Чадамж

Мэдлэг, ур чадвараа зорьсон үр дүнд хүрэхэд ашиглах чадвар

3.5 Аудитын шалгуур: Аудитын баримтыг харьцуулж эшлэл болгон ашиглах бодлого, журам зэрэг багц шаардлага.

3.6 Аудитын баримт: Аудитын шалгуурт хамааралтай бөгөөд магадлан шалгах боломжтой, бодит байдлын тухай бүртгэл, мэдэгдэл буюу бусад мэдээлэл.

3.7 Аудитын үр дүн: Аудитын шалгууртай харьцуулан цуглуулсан баримтад хийсэн үнэлгээний дүн.

3.8 Аудитын дүгнэлт: Аудитын зорилго болон аудитын үр дүнг авч хэлэлцсний дараах аудитын эцсийн дүн.

3.9 Аудитын хамрах хүрээ: Аудитын хүрээ, зааг хязгаар.

3.10 Аудитын төлөвлөгөө: Аудит явуулах арга хэмжээнүүд ба үйл ажиллагааг тодорхойлсон тайлбар.

3.11 Магадлах аудит: Менежментийн тогтолцоо нь холбогдох шаардлагад үргэлжлэн нийцэж буй эсэхийг тодорхойлох зорилгоор гэрчилгээний хүчинтэй хугацаанд тодорхой давтамжтай явуулах аудит.

3.15 Халал хүнс: Исламын Дүрмийн дагуу хэрэглэхийг зөвшөөрсөн мөн энэхүү стандартад тусгасан шаардлагад нийцсэн хоол хүнс, түүний дотор ундаа.

3.16 Халал эрх бүхий байгууллага (Исламын байгууллага): Гишүүн орнуудад зориулагдсан Исламын хамтын ажиллагааны байгууллага/ Исламын орнуудын стандарт хэмжилзүйн хүрээлэнтэй холбоотой стандартын Исламын үнэт зүйлсийн үндсэн дээр халалтай холбоотой асуудлуудад хяналт тавьдаг байгууллага.

3.17 Техникийн аудитор: Халал баталгаажуулалтын байгууллагаас албан ёсоор томилогдсон, халал журам болон шаардлагыг боловсруулалтын зохих технологи эсхүл салбарт аудит хийх техникийн чадавхтай хүн.

3.18 Исламын асуудлын шинжээч: Халал болон халал бус асуудлаарх Исламын дүрмийн талаар бүрэн, бүх талын мэдлэгтэй, мэргэжлийн чадавхийг нь холбогдох байгууллага (халал эрх бүхий байгууллага)-аас баталж, баталгаажуулсан, халал баталгаажуулалтын байгууллагаас томилсон лалын шашинтай хүн.

3.19 Халал тэмдэг: Халал баталгаажуулалтын байгууллагаас бүтээгдэхүүн/үйлчилгээ/ үйл явц мөн/эсхүл менежментийн тогтолцооны талаар олгосон Халал гэрчилгээгээр ашиглах эрхийг нь олгосон батлагдсан тэмдэг.

Баримт бичгийн нэр:		Халал баталгаажуулалтын журам	
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:		СХЗГ-07-ББ-14(01):2023	
Баталсан огноо:	2023.08.03	Баримт бичгийн хувилбар:	I

3.20 Өргөдөл гаргагч: Баталгаажуулалт хийлгэх хүсэлт гаргач хувь хүн эсхүл аж ахуйн нэгж.

3.21 Үл тохирол: Шаардлага үл биелэгдэх байдал.

3.22 Том үл тохирол

Халал тогтолцооны тодорхойлсон үр дүнд хүрэхэд нөлөө үзүүлэхүйц үл тохирол.

- ❖ ТАЙЛБАР: Том үл тохирлын нөхцөл байдлыг харгалзан үзэж дараах байдлаар ангилна:
 - а/ бүтээгдэхүүн буюу үйлчилгээг тогтоосон шаардлагад нийцүүлэх үйл явцын үр дүнтэй удирдлагыг хэрэгжүүлэхэд мэдэгдэхүйц хэмжээний эргэлзээ үүсэх;
 - б/ нэг шаардлагад үл нийцсэн хэд хэдэн үл тохирол буюу асуудал нь ерөнхий тогтолцоог гажуудуулах хэмжээний үл тохирол үүссэн тохиолдол;

3.22 Жижиг үл тохирол

Төлөвлөсөн үр дүнд хүрэх менежментийн тогтолцооны чадавхид тохирол нь нөлөөлөхгүй байх.

4. ХАЛАЛ ХҮНС

4.1 Шаритын хуулийн дагуу харамд тооцогдох ямар нэг зүйлээс бүрдээгүй, агуулаагүй хоол, хүнс, түүхий эд (зөвшөөрөгдсөн мал, амьтны мах)байна

4.2 Шаритын хуулийн дагуу харам зүйлээр бохирдсон ямар нэгэн төхөөрөмж/ байгууламж ашиглан үйлдвэрлэл явуулаагүй, бэлтгээгүй, боловсруулаагүй, тээвэрлэж хадгалаагүй хүнс

4.3 Шаритын хуулийн дагуу Нажс материал агуулаагүй байна

4.4 Хүнсний бүтээгдэхүүн нь хүний биед аюулгүй, хоргүй, эрүүл мэндэд хохирол учруулахгүй байна

4.5 Шаритын хуулийн дагуу Намжсын материалаар бохирдсон тоног төхөөрөмж ашиглан бэлтгээгүй, боловсруулаагүй, үйлдвэрлээгүй байна.

4.6 Шаритын хуульд заасны дагуу хүний бие махбодын хэсэг, түнээс гаргаж авсан зүйл агуулаагүй хүнс байна.

4.7 Хүнсний аюулгүй байдлын хувьд аюул заналтай зүйлс ороод ирвэл харам болно. (Ус шүүхэд хэрэглэдэг шүүлтүүр гахайн арьс байвал харамд тооцогдоно)

5. ХАЛАЛ АМЬТАД

5.1 Үхэр хонь, ямаа, тэмээ, тахиа, галуу, нугас, цацагт хяруул зэрэг гэрийн тэжээмэл амьтад

5.2 махчин биш зэрлэг амьтад буга, гөрөөс, янгир, зэрлэг үхэр зэрэг амьтад.

5.3 махчин биш шувуу (тагтаа, бор шувуу, бөднө шувуу)

6. ХАЛАЛ БУС АМЬТАД

6.1 Гахай, нохойн төрлүүд

6.2 Аллахын нэрийн өмнөөс төхөөрөөгүй амьтад

6.3 Исламын дүрмийн дагуу төхөөрөөгүй амьтад

6.4 өөрөө үхсэн амьтад

Баримт бичгийн нэр:		Халал баталгаажуулалтын журам	
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:		СХЗГ-07-ББ-14(01):2023	
Баталсан огноо:	2023.08.03	Баримт бичгийн хувилбар:	I

6.5 Өөрийгөө хамгаалахад ашигладаг урт үзүүртэй шүдтэй, соёотой амьтад (баавгай, заан, сармагчин, арслан, бар... гэх мэт)

6.6 махчин шувууд – шонхор, бүргэд, тас шувуу..... гэх мэт

6.7 хонь ямаа хог идвэл халал биш болно, гэхдээ 3 өдөр цэвэр хоол өгч, цэвэрлэсний дараа төхөөрч болно: энэ үед халалд тооцогдоно.

7. ХАЛАЛ БУС МАТЕРИАЛ

7.1 Бүх төрлийн цус, түүний гаралтай бүтээгдэхүүн нь халал бус юм

7.2 шээс, ихэс, ялгадас, бөөлжис, идээ бээр, эр бэлгийн эс, өндгөн эс зэрэг хүн, амьтнаас ялгарсан аливаа шингэн зүйл, эд зүйл хал бус.

7.3 хүний аль хэсэг нь хэрэглэхэд тохиромжгүй байдаг.

8. ХАЛАЛ НЯДАЛГААНЫ ДҮРЭМ

8.1 Халал амьтан байх

8.2 тэжээл нь халал байх

8.3 мал эмнэлгийн эрүүл мэндийн гэрчилгээтэй байх

8.4 Төхөөрөх гэж буй мал нь халал, халал аргаар тэжээгдсэн эрүүл байх

8.5 Нядалгаа хийх ажилтан нь насанд хүрсэн, Муслум шашинтай, нядалгаатай холбоотой дүерм нөхцөлийн мэдлэгтэй байх

8.6 Эрх бүхий байгууллагаас олгосон халал нядалгааны гэрчилгээтэй байх

8.7 Цэвэр гангаар хийсэн зэвэрдэггүй ган хутга, хурц ирмэгтэй байх

8.8 нядалгааны ажилтан нь эрүүл саруул оюун ухаантай, итгэл, сүсэгээ амаараа хэлэх чадамжтай.

9. НЯДАЛГААНЫ БАЙР

9.1 Зөвхөн халал нядалгаанд зориулсан САС RCP 1, эсвэл ISO 22000 стандартын угтвар нөхцөлийн шаардлагыг хангасан байна.

9.2 Мал нядалгааны газар нь Монгол Улсын хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль, Малын эрүүл мэндийн тухай хууль, техникийн зохицуулалтын шаардлага хангасан байх.

9.3 Мал орох хэсэгт амьтан өсгөхөд ашигладаг автоаматаар ажилладаг эргэдэг гинжин систем байна.

9.4 Автомат, хөдлөх эсвэл гар ажиллагаатай урсгалыг дараалалд оруулдаг эргэдэг гинжээр тоноглогдсон систем байна.

9.5 Бохир багаж, хутга угаах халдваргүйжүүлэх, ариутгах зориулалтын халуун усны систем, антисептик шингэн агуулах, хөл, өвдөг, фотоселлер ажилладаг цорго бүхий гар угаалтууртай байх

9.6 гарын цусаар бусад зүйлсийг бохирдуулахгүй байх.

Баримт бичгийн нэр:		Халал баталгаажуулалтын журам	
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:		СХЗГ-07-ББ-14(01):2023	
Баталсан огноо:	2023.08.03	Баримт бичгийн хувилбар:	I

10. НЯДАЛГААНЫ ДҮРЭМ, ЖУРАМ

10.1 Нядалгааны өмнө эрүүл мэндийн үзлэгийн стандарт, аргачлалын дагуу эрх бүхий байгууллагаас малын эмч гүйцэтгэдэг байх

10.2 Кибла рүү (Меккагийн зүг) харуулсан, нэг байрлалд удаан байлгаж болохгүй,

10.3 Мал нь өмнөх төхөөрч байгаа малаа харах ёсгүй байх бөгөөд хаалт хийсэн байх

10.4 Мал төхөөрөгч нь АЛЛАХЫН нэрийн өмнөөс гэсэн утгатай “БИСМИЛЛАХ” гэдэг үгийг хэлнэ.

10.5 Эрх бүхий малын эмч гулууз маханд үзлэг хийнэ

10.6 Нядалгааг мал тус бүрт нэг удаа хийнэ.

10.7 Гулууз махыг угааж гаднах механик бохирлоос нь салгаж, хүнсний зориулалтын бэхээр гулууз махыг тамгална, эсвэл гулуузанд тэмдэглэгээ мөшгөх нөхцөлийг хангасан зүүлт зүүж болно.

10.7 Цус алдах хугацаа нь цус гарах, амьтан бүрэн үхэхэд хангалттай хугацаа байх ёстой.

10.8 Махнаас дээж авч, дээжний хариу гартал цааш үйлдвэрт шилжүүлэхгүй.

10.9 автоаматаар төхөөрч байхад үхвэл зайлуулна энэ нь харам юм.

10.10 ариун цэвэр, эрүүл ахуй, хяналтын эгзэгтэй цэг, аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт, аюулыг бүхэлд нь шалгана.

10.11 төхөөрөхөөс өмнө талбай цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

11. БАТАЛГААЖУУЛАЛТ

11.1 Халал баталгаажуулалт нь GSO 2055-1; GSO 2055-2; ISO/IEC 17065 ISO 19011; ISO /TS 22003 стандартын шаардлагад нийцсэн байна.

11.2 Баталгаажуулалт хийлгүүлэх өргөдөл гаргагчийн халал баталгаажуулалтын хамрах хүрээг аудитын дүнгээс хамааруулан аудитын баг тогтооно.

11.3 Халал стандарт хэрэгжүүлсэн үйлдвэр, бүтээгдэхүүний хамрах хүрээг өргөдөл гаргагч байгууллага тогтоох ба эцсийн бүтээгдэхүүний хүнсний аюулгүй байдалд нөлөөлж болох үйл ажиллагаа, үйл явц, бүтээгдэхүүн буюу үйлчилгээг баталгаажуулалтын хамрах хүрээнээс хасч болохгүй.

11.4 Өргөдөл гаргагчийн халал тогтолцоонд аудитыг газрын даргын тушаалаар томилогдсон аудитын баг явуулах ба аудитын багт Исламын аудитор, техникийн аудитыг багтаасан байна. Шаардлагатай гэж үзвэл техникийн шинжээч ажиллаж болно.

11.5 Аудитын баг хамгийн багадаа 2 хүн байна, үүний нэг нь Исламын аудитор, нөгөө нь техникийн аудитор байна. Аудитын багийг томилохдоо аудиторын боловсрол, мэдлэг, сургалт, ажлын туршлагыг харгалзан авч үзэх ёстой.

11.6 Халал баталгаажуулалтын зөвлөл нь 100 хувь Ислам шашинтай 3 хүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн 100 хувийн шийдвэрээр гэрчилгээ олгоно.

11.7 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоог баталгаажуулах үйл явцын зураглал/схемийг **1 дүгээр хавсралтаар** үзүүлэв.

11.8 Халал баталгаажуулалт хийлгүүлэх өргөдлийг **хавсралт 2 -ын** дагуу баталгаажуулалтын байгууллагад гаргана.

Баримт бичгийн нэр:		Халал баталгаажуулалтын журам	
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:		СХЗГ-07-ББ-14(01):2023	
Баталсан огноо:	2023.08.03	Баримт бичгийн хувилбар:	I

11.9 Өргөдөл гаргагч нь халал стандартын тогтолцоог үйл ажиллагаандаа хамгийн багадаа 9 сар хэрэгжүүлсэн байх ба тус тогтолцоог хэрэгжүүлсний үр дүнг үнэлж баталгаажуулалт хийлгүүлэх менежмент шийдвэрт хүрсэн байна.

11.10 Өргөдөл гаргагчийн хэрэгжүүлсэн халал стандартыг баримтжуулсан баримт бичиг нь баталгаажуулалтын байгууллагаас тогтоосон шаардлагад нийцсэн байна.

11.11 Аудитаар илэрсэн үл тохирлын залруулах хугацааг тухайн үл тохирол нь халал стандартын шаардлагад нөлөөлөх байдлаас хамааруулан тогтоох ба үл тохирол залруулах хугацаа 3 сараас дээш байж болохгүй. Хугацаандаа тухайн үл тохирол залруулагдаагүй бол аудит давтан хийнэ.

12. БАТАЛГААЖУУЛАЛТАД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

12.1 Баталгаажуулалтын байгууллага:

12.1.1 Өргөдөл гаргагчийн хэрэгжүүлсэн халал стандартын хамрах хүрээг тус тогтолцоог үнэн зөв, үр дүнтэй хэрэгжүүлсэн байдал болон аудитын дүнгээс хамааруулан багасгаж болно.

12.1.2 Гэрчилгээжсэн байгууллагатай гэрээний дагуу халал стандартын тогтолцоонд магадлах аудит хийх;

12.1.3 Гэрчилгээжсэн байгууллага нь баталгаажуулалтын шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд гэрчилгээг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

12.1.4 Өргөдөл гаргагчаас шаардлагатай баримт бичиг, мэдээллийг гаргуулах;

12.1.5 Аудитын багийн бүрэлдэхүүнийг үйлчлүүлэгчдэд мэдээлэх, санал авах.

12.1.6 Баталгаажуулалтын байгууллагаас бүтээгдэхүүн/үйлчилгээ/д олгосон халал тэмдэг /логог бүтээгдэхүүн тус бүр дээр тавих, мөн бүтээгдэхүүний гаднах хайрцаганд тавих, батлагдсан тэмдэг ашиглуулахыг шаардах.

12.1.7 Гэрчилгээжсэн байгууллагад гэнэтийн аудитыг явуулна.

12.2 Аудитаар шалгуулагч/өргөдөл гаргагч байгууллага:

12.2.1 Халалт баталгаажуулах хүсэлтийг “хавсралт-2”-ийн дагуу баталгаажуулалтын байгууллагад гаргах;

12.2.2 Халал гэрчилгээ эзэмшигч нь баталгаажуулалтын байгууллагатай гэрчилгээ эзэмших гэрээ байгуулж ажиллах;

12.2.3. Баталгаажуулалт, аудитын дүнгийн талаар санал, гомдлыг халал баталгаажуулалтын байгууллагад гаргах;

12.2.4 Аудитын багийн бүрэлдэхүүнд багтсан Исламын аудитор, техникийн аудитор_ техникийн шинжээчээр аудит гүйцэтгүүлэхгүй байх саналаа халал баталгаажуулалтын байгууллагад гаргах.

12.2.5 Илэрсэн үл тохирлыг тогтоосон хугацаанд залруулах;

12.2.6 Исламын дүрэм, үнэт зүйлс, ёс зүйг ханган ажиллах ба хяналт тавьж ажиллах;

12.2.7 Баталгаажуулалтын байгууллагаас олгосон халал гэрчилгээ, тэмдгийг баталгаажсан бүтээгдэхүүнд хэрэглэх, тэмдэгийг хэрэглэгчийг төөрөгдүүлэхгүйгээр үнэн зөв баталгаажсан бүтээгдэхүүнд ашиглана.

13. АУДИТЫН ОБЪЕКТ

Аудитор нь ХАЛАЛ баталгаажуулалтын аудитыг дараах объектуудад явуулна. Үүнд:

- Менежментийн тогтолцоог хэрэглэх хүрээ;
- Халал хүнс үйлдвэрлэх нядалгааны байр, ажлын орчин, дэд бүтэц;
- Халал стандартын шаардлагын баримт бичгүүд;

Баримт бичгийн нэр:		Халал баталгаажуулалтын журам	
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:		СХЗГ-07-ББ-14(01):2023	
Баталсан огноо:	2023.08.03	Баримт бичгийн хувилбар:	I

- Хяналтын цэг болон хяналтын эгзэгтэй цэг;
- НАССР төлөвлөгөө, угтвар нөхцөл, аюулын дүн шинжилгээ;
- Исламын дүрэм, журмын нийцэл, халал шаардлага. (GSO 993; GSO 2055-1 бусад)
- олон байршилтай байгууллагын хувьд байршил(on site) бүрт аудитын хийх.

14. ХАЛАЛ СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛСНИЙГ НОТЛОХ БАРИМТ БИЧГҮҮД

14.1 Халал стандартыг хэрэгжүүлснийг баримтжуулсан гарын авлага, баримт бичиг, лавлагаа мэдээлэл

14.1 Баталгаажуулалтын шаардлагыг хангуулах, хангагдсан байхыг шаардах баталгаажуулалтын байгууллагаас тогтоосон баримт бичиг.

14.3 САС RCP 1 стандартаар бүрдүүлсэн баримт бичгүүд

14.4 Шаардлагатай бусад баримт бичиг.

15. БАТАЛГААЖУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ

Халал стандартын баталгаажуулалт нь дараах үйл явцаас бүрдэнэ:

Баталгаажуулалтын өмнөх ажиллагаа,

Баталгаажуулалтын аудит.

- Анхны баталгаажуулалтын аудит (1, 2 дугаар шат),
- Аудит явуулах;
- HALAL гэрчилгээ олгох, тэмдэг хэрэглүүлэх, татгалзах шийдвэр гаргах, баталгаажуулах;
- Баталгаажуулалтын гэрээ байгуулах;
- Гэрчилгээжсэн аж ахуйн нэгж, байгууллагыг бүртгэж, холбогдох мэдээллийг www.masm.gov.mn цахим хуудсанд мэдээлнэ.
- Гэрчилгээний хүчинтэй хугацаанд явуулах магадлах аудит,
- Баталгаажуулалтын мөчлөгийн дараа гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас өмнө хүсэлтийн дагуу давтан баталгаажуулалтыг явуулна.

15.1 БАТАЛГААЖУУЛАЛТЫН ӨМНӨХ АЖИЛЛАГАА

15.1.1 Баталгаажуулалтад хамрагдах хүсэлт гаргах

- Халал баталгаажуулалт хийлгүүлэх хүсэлт/өргөдөл гаргагч нь (**Хавсралт 2**)- д заасан өргөдлийг үнэн зөв, бүрэн гүйцэд бөглөсөн өргөдөл болон баталгаажуулалтын байгууллагаас тогтоосон баримт бичгийн хамт баталгаажуулалтын байгууллагад ирүүлнэ. Мөн www.masm.gov.mn цахим хуудсаар дамжуулан хүсэлтээ ирүүлж болно.
- Өргөдөл, шаардлагатай материалыг www.masm.gov.mn цахим хуудсанд байршуулсан байна.
- Баталгаажуулалтын байгууллага нь шаардлагатай тохиолдолд хүсэлт/өргөдөл гаргагч байгууллагаас ХАЛАЛ стандартын үйл явцын шугам, аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналтын судалгаа, ээлжийн ажилтны тоо, халал хүнсний талаар болон бусад холбогдох нотлох баримт мэдээллийг шаардаж болно.

15.2 Өргөдлийн дүн шинжилгээ

- Баталгаажуулалтын байгууллага нь өргөдөл гаргагчийн өргөдлийг хүлээн авч өргөдөл, холбогдох баримт бичигт (**Хавсралт 3**)-ын дагуу дүн шинжилгээг хийнэ.
- Өргөдөл, холбогдох баримт бичигт хийсэн дүн шинжилгээний дүнг тухайн асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр хянуулж, тус тогтолцоог хэрэгжүүлсэн нь баримтжуулалтын баримт бичгийн түвшинд шаардлага хангасан тохиолдолд аудитыг газар дээр нь явуулах шийдвэр гаргана..

Баримт бичгийн нэр:		Халал баталгаажуулалтын журам	
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:		СХЗГ-07-ББ-14(01):2023	
Баталсан огноо:	2023.08.03	Баримт бичгийн хувилбар:	1

- Баталгаажуулалтын байгууллага нь хүсэлт/өргөдлийг хүлээн авснаас хойш ирүүлсэн өргөдөл, холбогдох баримт бичиг, материалд дүн шинжилгээ хийх, судлах асуудлыг "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хуульд заасан хугацаанд хийх, хэрвээ хүсэлт/өргөдөл гаргагчийн баримт бичгийн бүрдэл дутуу, шаардлага хангахгүй, дүн шинжилгээ хийх боломжгүй тохиолдолд энэ тухай тайлбарыг баримтжуулан өргөдөл гаргагчид мэдээлнэ, шаардлагатай бол баримт бичигт дүн шинжилгээ хийсэн дүнг албан ёсоор хүргүүлнэ. Өргөдөл гаргагчийн хүсэлтийн явцын талаар мэдэгдэж, харилцаа холбоо тогтоож эргэх холбоотой ажиллах ба харилцаа холбоо тэмдэглэлийг **Хавсралт 5-ийн** дагуу хөтөлнө.

- Өргөдөл, баримт бичигт хийсэн дүн шинжилгээний дүнг үндэслэн аудитын багийг томилох бөгөөд бүртгэлтэй аудиторруудаас (шаардлагатай бол техникийн шинжээчид) сонгож аудитын багийг бүрдүүлнэ.

- Өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны түвэгшил, цар хүрээ, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явц, салбараас хамаарч баримт бичигт дүн шинжилгээг хийх нэмэлт хугацааг тогтоож болно.

- Аудитыг газар дээр нь хийх хугацааг үйлчлүүлэгчтэй харилцан тохиролцож, баталгаажуулалтын байгууллага доорх бэлтгэл ажлыг хангасан байна. Үүнд:

a/ аудитын хөтөлбөрийг боловсруулах; **Хавсралт 4-ийн дагуу.**

b/ аудитын хугацааг тодорхойлох; *Аудитын хугацаа, олон байршлийн түүвэрлэлтийг тогтоох журам-СХЗГ-07-ББ-10(03)2023.*

c/ түүвэрлэлтийн арга, хөтөлбөрийг боловсруулах.

d/ аудитын зорилго, хамрах хүрээ, шалгуурыг тогтоох; холбогдох стандартын дагуу бэлтгэсэн шалгах хуудасны дагуу. **Хавсралт 16**

e/ аудитыг төлөвлөгөөг боловсруулах; **Хавсралт 5-ын дагуу.**

f/ аудитын багийн гишүүдийн санал авах, мэдээлэх; **Хавсралт 6-ын дагуу.**

g/ аудиторыг сонгох, томилох; **Халал баталгаажуулалтад үйл ажиллагаанд оролцогч ажилтнуудын чадамжийн бүртгэл- Хавсралт 19.**

Аудитын багийн гишүүдийн тоо, бүрэлдэхүүнийг томилохдоо дараах асуудлыг авч үзсэн байна. Үүнд:

- Аудитын хамрах хүрээ, шалгуур, үргэлжлэх хугацаа;

- Аудитын багийн гишүүдийн үр нөлөөтэй хамтран ажиллах чадавхи;

- Баталгаажуулалтын шаардлага (хууль тогтоомж, зохицуулалт, гэрээний шаардлага);

- Хэл, нийгэм соёлын талаарх ойлголт.

- Бүтээгдэхүүний үйл явц, төвөгшил, зохион байгуулалт;

- Хяналтын эгзэгтэй цэг, эрсдэл, аюул.

- Мусульман шашны ариун зан үйлийг айлдаж, зүй бус үйлдлээс урьдчилан сэргийлэх

Исламын зарчмуудын багцын сургалтад хамрагдсан, итгэгч хүнийн мэдээлэл, чадамж

- Халал хүнсний шаардлага нийцлийн 1 шатны аудитын үр дүн, тайлан үл, тохирлын тоо хэмжээ.

Аудиторыг сонгох, томилоход "Менежментийн тогтолцооны аудиторын дүрэм"-д заасан чадамжийг эзэмшсэн, мониторингийн үнэлгээгээгээр хангалттай үнэлэгдсэн, аудитын үйл ажиллагаанд үр нөлөөтэй оролцсон байдал зэргийг авч үзнэ. Аудитын багийн бүрэлдэхүүн нь багийн ахлагч, гишүүнээс бүрдэх бөгөөд шаардлагатай тохиолдолд техникийн шинжээч, орчуулагч, хөтөч, ажиглагчийг татан оролцуулна. Халал баталгаажуулалтын хувьд Исламын шашинтай, шашны ариун зан үйлийг эрхэмлэдэг Исламын аудитор, техникийн аудиторын

Баримт бичгийн нэр:		Халал баталгаажуулалтын журам	
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:		СХЗГ-07-ББ-14(01):2023	
Баталсан огноо:	2023.08.03	Баримт бичгийн хувилбар:	I

бүрэлдэхүүнтэй баг байна. Аудитын багийн ахлагч багийн бусад гишүүдтэй зөвшилцөж багийн гишүүн бүрд аудитын чиг үүрэг эсхүл ажиллах байршил, объектыг хуваарилна. Энэ хуваарилалтыг хийхдээ аудиторчуудын чадамж, мэргэшлийн байдал, аудитын үр дүнгээс гарах эрсдлийг тооцсон байна. Мөн аудитор, дадлагажигч аудитор, техникийн шинжээчийн үүрэг хариуцлагыг авч үзсэн байвал зохино. Аудитын явцад аудитын зорилтуудыг хангах зорилгоор ажлын хуваарилалтыг өөрчилж болно. Аудитын хугацаанд аудиторчууд ажиллаагүй хүнийг (хөтөч, орчуулагч, ажиглагч) аудитын хугацаа тооцоход авч үзэхгүй.

- h/** аудитын баримт бичгийг бэлдэх.
- i/** Аудитын төлөвлөгөөг мэдээлэх;
- k/** Аудитыг явуулах (1 ба 2-р шатны).

15.3 АУДИТ ЯВУУЛАХ

15.3.1 АНХДАГЧ БАТАЛГААЖУУЛАЛТЫН АУДИТ

Халал баталгаажуулалтын анхдагч аудитыг хоёр үе шаттай хийнэ.

1 ДҮГЭЭР ҮЕ ШАТ

1-р үе шатны аудитын зорилт нь Халал стандартын баримтжуулалт, тодорхойлолт, шинжилгээ, НАССР эсхүл Халал хяналтын төлөвлөгөө, урьдчилсан нөхцөл хөтөлбөрүүд, бодлого болон зорилтуудыг хянах замаар байгууллагын аудитад бэлэн байдлыг хянах, тухайн халал үйлдвэрлэлийн талаар ойлголттой болсоны үндсэн дээр хоёрдугаар шатны аудитыг төлөвлөхөд чиглэгдэнэ. Халал баталгаажуулалтын хувьд, нэгдүгээр үе шатыг хүсэлт гаргагчийн ажлын байранд явуулна. 1-р үе шатны аудитыг үйл ажиллагааны талаар үйлчлүүлэгчид мэдэгдэнэ.

2-р шатны аудитыг төлөвлөлтийг хийхийн тулд 1 дүгээр шатны аудитыг хүсэлт гаргагчийн ажлын байранд хэрэгжүүлэх ба аудитаар доорх зүйлүүдийг тогтооно.

1 дүгээр шатны аудитаар дараах ажлуудыг гүйцэтгэнэ:

- Үйлчлүүлэгчийн халал стандартын тогтолцооны баримтжуулалтанд аудит хийх;
- Үйлчлүүлэгчийн байрлал, газар орны онцлог нөхцөлийг үнэлж, 2 дугаар шатны аудитын бэлэн байдлыг тодорхойлох;
- Үйлчлүүлэгчийн халал стандарт хэрэгжүүлсэн хамрах хүрээг бататгах;
- Тухайн стандарттай холбоотой, ялангуяа хэрэгжүүлсэн менежментийн тогтолцооны гүйцэтгэл буюу голлох чиглэлүүд, үйл явц, зорилтууд, ажиллагааны талаарх холбоотой үйлчлүүлэгчийн байр суурь, ойлголтыг хянан үзэх;
- Үйлчлүүлэгчийн байршил(ууд), холбогдох хууль зохицуулалтын асуудал, нийцлийн тухай шаардлагатай мэдээллийг цуглуулах;
- Дотоод аудит төлөвлөсөн болон гүйцэтгэсэн эсэхийг үнэлж, халал стандартын тогтолцооны хэрэгжилтийн төвшин нь үйлчлүүлэгчийг 2 дугаар шатны аудитад бэлэн болохыг хангалттай баталгаа болж байгааг үнэлэх;
- Байгууллагын угтвар нөхцлүүдийг тогтоосон (хууль тогтоомж, дүрэм, журам, хэрэглэгчийн болон баталгаажуулалтын схемийн шаардлага зэрэг) эсэхийг үнэлэх;
- Хүнсний аюулгүй байдалд учирч болох аюулыг тогтоож, үнэлснийг үнэлэх;
- Хяналтын арга хэмжээ болон сайжруулалтын хөтөлбөрүүд Халал стандартад тохирсон байхыг шалгах;

Баримт бичгийн нэр:		Халал баталгаажуулалтын журам	
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:		СХЗГ-07-ББ-14(01):2023	
Баталсан огноо:	2023.08.03	Баримт бичгийн хувилбар:	I

- Халал хүнсний төрөл бүрийн бүтэцийн нөхцөл шаардлага, хангалт.

15.3.2 Нэгдүгээр шатны аудитын илрүүлэлтийг баримтжуулж, үйлчлүүлэгчид мэдээлэх бөгөөд нэгдүгээр шатны аудитын үр дүнгээр хоёрдугаар шатны аудитыг хойшлуулах эсхүл цуцлахад хүргэж болзошгүй байдлыг өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.

15.3.3 Нэгдүгээр шат болон хоёрдугаар шатны аудит хоорондын зай нь 6 сараас дээшгүй байна гэж тооцоолж байна. Хэрэв аудит хоорондын илүү урт хугацаа шаардлагатай бол нэгдүгээр шатны аудитыг давтан гүйцэтгэнэ.

15.3.4 1 дүгээр шатны аудитын талаарх тайланг “**Хавсралт - 7**”-ын дагуу үйлдэнэ.

15.3.5 1 дүгээр шатны аудитыг удирдамжийн дагуу гүйцэтгэх ба 1 дүгээр шатны аудитад тусгайлан аудитын төлөвлөгөө боловсруулахгүй.

15.3.6 1 дүгээр шатны аудитыг гүйцэтгэхэд албан ёсны аудитын баг томилогдохгүй бөгөөд өргөдөл гаргагчийн хүсэлтийг хүлээн авсан аудитор аудитыг явуулна.

15.4 2 ДУГААР ШАТНЫ АУДИТ

15.4 2 дугаар шатны аудитын зорилго нь үйлчлүүлэгчийн халал стандартын хэрэгжүүлэлтийн байдал, үр нөлөөг үнэлэх зорилгоор явуулах ба аудитыг үйлчлүүлэгчийн ажлын байранд хийнэ. 2 дугаар шатны аудитад стандартаар заасан шаардлагын дагуу үнэлж, холбогдох мэдээлэл, нотолгоог баримтжуулна.

15.4.3 2 дугаар шатны аудитаар хийгдэх ажлууд:

- Нээлтийн хурал хийх; (**Хавсралт - 8**)-ын дагуу
- Аудитын явцад мэдээлэл, харилцаа холбоо тогтоох;
- Аудитын багийн ахлагч аудитын үйл ажиллагааг үргэлжлүүлэх боломжгүй тохиолдолд үйлчлүүлэгч талд мэдэгдэх;
- Аудитын явцад аудитын зорилго, хүрээ, шалгууртай холбоотой мэдээллийг цуглуулж, нотолгоо болгохын тулд баримтжуулах;
- Аудитын үр дүнг тодорхойлох, бүртгэх (үл тохирол) (**хавсралт-9**);
- Аудитын дүгнэлт гаргах; (**хавсралт-10**)
- Хаалтын хурал хийх. (**хавсралт-11**) -ийн дагуу баримтжуулна.

(Тайлбар: GSO 2055-2 *стандартын холбогдох бүлгийн шаардлагыг авч үзэж, хангана*)

15.4.4 Аудитын явцад харилцах

Аудитын баг аудитын талаар мэдээлэл солилцож, аудитын явцыг үнэлж байвал зохино. Аудитын багийн ахлагч аудитын багийн гишүүдийн хооронд ажлаа дахин хуваарилах, үйлчлүүлэгчид аудитын үйл явц болон илэрсэн асуудлыг тодорхой хугацаанд тогтмол мэдээлнэ. Аудитын явцад цуглуулсан баримт нь үйлчлүүлэгчид шууд болон ноцтой (жишээ нь, аюулгүй ажиллагаа) эрсдэл учруулах бол цаг алдалгүй үйлчлүүлэгчид, хэрэв боломжтой бол авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлуулах зорилгоор баталгаажуулалтын байгууллагад мэдэгдэнэ. Аудитын зорилго хангагдахгүй болохыг нотолсон баримтыг үйлчлүүлэгчид мэдэгдэнэ.

15.4.5 Анхдагч баталгаажуулалт ба тайлан, дүгнэлт

2 дугаар шатны аудитын явцад цуглуулсан мэдээлэл, аудитын нотлох баримтанд задлан шинжилгээ хийж, халал стандартын хэрэгжүүлэлтийн тогтолцоо нь стандартын шаардлагыг

Баримт бичгийн нэр:		Халал баталгаажуулалтын журам	
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:		СХЗГ-07-ББ-14(01):2023	
Баталсан огноо:	2023.08.03	Баримт бичгийн хувилбар:	1

бүрэн хангаж байгааг үнэлсэн талаар анхдагч аудитын дүгнэлтийг аудитын баг “Хавсралт - 10”-ын дагуу үйлдэнэ.

15.4.6 Аудитын үр дүнг тодорхойлох, бүртгэх (илэрсэн үл тохирол) залруулах

Аудитын дүнгээр үл тохирол илэрсэн бол үл тохирлыг “Хавсралт - 9”-ын дагуу бүртгэж, үйлчлүүлэгч болон баталгаажуулалтын байгууллага үл тохирлыг залруулах хугацааг зөвшилцөн аудитын тайланд тэмдэглэх ба үйлчлүүлэгч тал заасан хугацааны дотор залруулах арга хэмжээг авч, залруулсан талаарх тайланг нотолгоо баримтын хамтаар баталгаажуулалтын байгууллагад албан ёсоор ирүүлнэ.

15.4.6 Тайланд тэмдэглэгдсэн үл тохирлыг залруулсан байдлын үр нөлөөний тайланг халал баталгаажуулалтын байгууллагад ирүүлсний дараа үл тохирол залруулсан тайланд хяналт хийх ба шаардлагатай бол газар дээр нь хянаж баталгаажуулан, үл тохирлыг хаана.

15.4.7 Үл тохирлыг залруулах хугацааг 3 сараас хэтрэхгүйгээр тогтоож өгнө.

15.4.8 Техникийн шинжээч нь хаалтын хурал дээр үг хэлэх эрхгүй, аудитын багт аудитын тайлан өгөх ба үл тохирол илрүүлэхгүй.

15.5 Баталгаажуулалтын тухай шийдвэр (гэрчилгээ олгох, тэмдэглэгээ хэрэглүүлэх)

15.5.1 Баталгаажуулалт олгох буюу татгалзах, хүрээ өргөтгөх буюу багасгах, цуцлах буюу сэргээх зэрэг шийдвэр гаргах чиг үүргийг халал баталгаажуулалтын шийдвэр гаргах зөвлөл гүйцэтгэнэ.

15.5.2 Аудитын багийн ахлагч нь аудитын тайлан, дүгнэлтийг (хавсралт - 12)-ийн дагуу бэлтгэж Халал баталгаажуулалтын зөвлөлд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулж ажиллана.

15.5.3 Аудитын баг баталгаажуулалтын шийдвэр гаргахад доорх материал, баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

- аудитын тайлан
- үл тохирол, түүнийг залруулсан байдал;
- өргөдөл, баримт бичигт дүн шинжилгээ хийсэн тайлан;
- аудитын үр дүнг нотлох баримт бичгүүд;
- Баталгаажуулалтыг олгох, эс олгох дүгнэлт, зөвлөмж, бусад баримт бичиг.
- үйлчлүүлэгчийн халал стандарт хэрэгжүүлснийг нотлох баримт бичгүүд.

15.5.4 Шийдвэрийг үндэслэн гэрчилгээг олгож, гэрээ байгуулан ажиллана. Гэрээнд гэрчилгээ эзэмшигч ба баталгаажуулалтын байгууллагын эрх үүрэг, хариуцлага, гэрчилгээний хамрах хүрээ, хугацаа, гэрчилгээ эзэмших эрхийг зогсоох, хүчингүй болгох, давтан баталгаажуулалт хийх болон халал тэмдэг хэрэглэх нөхцөлүүдийг тусгаж өгнө.

15.5.5 Аудитын баг/аудитор нь хавсралт 02-12-д заасан бүртгэлийг хөтөлж баталгаажуулан аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болгон ашигласан материалын хамт халал баталгаажуулалтын асуудал хариуцсан ажилтанд хүлээлгэн өгнө.

15.6 Баталгаажуулалтыг хадгалах

Баталгаажуулалтын байгууллага нь үйлчлүүлэгч халал стандартын шаардлагуудыг үргэлжлүүлэн хангаж байгаа байдалд үндэслэн баталгаажуулалтыг хадгална.

Энэ нь цаашид бие даасан дүн шинжилгээ хийхгүйгээр дараах зүйлийг хангах аудитын багийн эерэг дүгнэлтэнд үндэслэн үйлчлүүлэгчийн баталгаажуулалтыг хадгална. Үүнд :

а) аливаа үл тохирол буюу бусад нөхцөл байдал нь баталгаажуулалтыг түдгэлзүүлэх буюу хүчингүй болгоход хүргэж болох тул баталгаажуулалтын байгууллага нь баталгаажуулалтыг хадгалж болох эсэхийг тодорхойлуулахын тулд аудитыг гүйцэтгэсэн ажилтнаас өөр тохирох ур чадвар бүхий ажилтанг томилон дүн шинжилгээ хийлгэж

Баримт бичгийн нэр:		Халал баталгаажуулалтын журам	
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:		СХЗГ-07-ББ-14(01):2023	
Баталсан огноо:	2023.08.03	Баримт бичгийн хувилбар:	I

баталгаажуулалтын байгууллагад тайлагнахыг аудитын багийн ахлагчаас шаардах тогтолцоотой байх ;

b) баталгаажуулалтын үйл ажиллагаа үр нөлөөтэй явагдаж буй эсэхийг нотлох зорилгоор аудиторчуудын тайланд мониторинг хийх ажлыг оролцуулан магадлан хяналтын үйл ажиллагааг баталгаажуулалтын байгууллагын ур чадвар бүхий ажилтан гүйцэтгэнэ.

15.7 Магадлах аудит

